

ДОРНЫН СОНГОДОГ  
ЗОХИОЛЫН ЦОМОРЛИГ

ЭРТНИЙ ЭНЭТХЭГИЙН АЛДАРТ  
СУРГААЛ «ЗОРИУД ӨГҮҮЛЭХҮЙ  
ЦОМОРЛИГ» БА «НОМЫН БАДАГ»

Монголчууд олон зуун жилийн өмнөөс дэлхий дахины соёл, шинжлэх ухааны гайхамшигт эрдэнэсийн уурхай хэмээгдэх Бурхан буддагийн мэндэлсэн өлгий Энэтхэг оронтой холбоо харилцаатай явж ирсэний нэг ул мөр бол «Зориуд өгүүлэхүй цоморлиг» (Уданаварга) шүлэглэлийг тайлбарын хамт XVII—XVIII зуунд эх хэлэндээ орчуулан «Ганжуур» (Зарлигийн орчуулга), «Данжуур» (Шаштирын орчуулга) номоор дамжуулан уншиж судлан ирсэн явдал юм. Энэхүү Ганжуур, Данжуурт орсон монгол орчуулга нь «санскритээс төвд хэлэнд орчуулсан төвдийн хэлмэрч Ринчинчогийн IX зууны үед орчуулсан нэг ном болой» гэж хожмын орчуулагчид тэмдэглэжээ. Зориуд өгүүлэхүй цоморлиг номын шүлгээс хэсэгчлэн буулгаж бидний дээд үе ямаршуу сургаал зохиолыг эх хэлэндээ хэрхэн орчуулж байсныг уншигчиддаа цухас төдий танилцуулахыг зорилоо. Харин 2-3 зуун жилийн өмнөх эхээр хэвлэсэн тул ухахуйд хэцүү үг, тайлахад бэрх утга тааралдаж байв. Гэвч гуйвуулан мушгихгүйг хичээн боломжийн гэж үзсэнээ түүж авсан болно. Жишээ нь:

Номын 128-р талын Амрагийн цоморлигт:

«Бүгд бээр амин ину амраг  
Бүгдээрийг цааз бээр айлгагч болбасу л  
Өөрийн оюундаа үлэгдэх буюу  
Хөвсөн үл үйлд! Алан үл үйлд» гэсэн байв.

Үүнийг: «Аминдаа амьтан бүгд хайртай

Ардыг айлгагч хууль цааз бариачин

Өөртэйгээ жишиж бодох юм гэвэл

Өнөд бүү сүрдүүл! алж бүү сүйтгэ» гэж ухахуйд хялбар болгохыг хичээв.

Хоёр дахь шүлэглэл «Номын бадаг» (Дхармапада)-ийг 1960 онд ЗХУ-д орчуулж, хожим Очирын Батдалай түүнээс монголд орчуулсан дутуу эх байдаг. 1959 онд Гандан хийдийн номч, гэвш Ш. Иштавхай гуай 1944 оны үес пали хэлнээс Гэнпэнпилийн төвдөд орчуулсан эхээс монголд орчуулсан нь монгол уншигчдыг энэ хөлгөн судартай нүүр учруулж, нүд тайлуулсан их буян ажээ. «Номын бадаг»-ийн бүх шүлэг өмнөх сургаалд бараг тэр хэвээрээ байдаг тул давхардуулахгүйн тулд цөөн бадаг авч «у» үсэг бичив.

**Нэг. МӨНХ БУСЫН ЦОМОРЛИГ**

у. Аяа хуран үүдсэн бүгд мөнх бус

Төрөөд эвдрэх нь номонд ч буй

Төрж буй бүхэн эвдрэн өгүүтгэгч буюу

Тэдгээр бүхэн түргэнээ амарливаас жаргалан тэр

у. Олон эрэгтэй эмэгтэй ба

Идэр ахуйдаа үхэх бөгөөтөл

Энэ хүн залуу хэмээн

Эрэмшин нотлох арга юун

у. Заримууд хэвлийд (умай) үхэх болно

Түүнчлэн заримууд төрсөн газарт

Түүнчлэн заримууд мөлхөх төдийд

Түүнчлэн заримууд насан идэрт

у. Үлгэрлэвээс боловсорсон үрнүүд

Унасаар настнуудад нэгийг бодуулна

Түүнчлэн өсөж залуужиж буй хүн

Настнуудын үхлээс нэгийг бодуулна  
 у. Түргэн урсах мөрний урсгал  
 Буцалтгүй явж оддогийн адил  
 Түүнчлэн хүний нас ахин ахисаар  
 Харьж буцахгүй талийн одно.  
 у. Үлгэрлэвээс малчин хүн шилбүүрээр  
 Малуудаа тууж хороонд оруулах мэт  
 Түүнчлэн өвчин тусах, өтлөх алин авч  
 Хүнийг үхлийн зүг тууж яваа нь буюу  
 у. Өчүүхэн голын ус урсан урссаар  
 Өдөр шөнө өнгөрөх бүр барагдахын адил  
 Хүний насны хэмжээ яван явсан барагдаад  
 Хөсөр унан үгүйрэх нэгэн адил  
 у. Жишүүл (сахиул) бологсдод шөнө урт  
 Явж ядрагсдад хөрш хол  
 Дээд номыг магад үл мэдэгч  
 Дэвэргэн багачуудад орчлон хол  
 у. Надад хүү ч бий, эд ч бий хэмээн  
 Өчүүхэн бодолтнууд бардамнан сэтгэнэ  
 Өөрөө байх үгүйгээ мэдэхгүй байж  
 Чамд юуны хүү, юуны эд байх билээ.  
 у. Эрэгтэй эмэгтэйн ялгал гээч  
 Олон зуун мянган тоотон  
 Эд уурс хэдүй их хураах ахул  
 Үхлийн эзнийхээ эрхэнд ойртож буй  
 у. Хураасан бүгд эцэстээ барагдана  
 Босгосон бүгд эцэстээ нурах нь лав  
 Учирсан бүгд эцэстээ хагацна  
 Амьд явахын эцэст үхэх нэгэн буй  
 у. Хаан суудалдаа ихэд мяраалбаас  
 Түүнчлэн бие нь өтлөх буюу  
 Ихсийн номыг даган биширвээс  
 Их өтлөх нь багасах учир буй  
 у. Бяцхан горхины доторхи загас мэт  
 Бядан явж өдөр хоног өнгөрөөхүй  
 Энэ насан тийн богино атал  
 Элдэв баясал жаргал үйлдэх юун бэ?

**Хоёр. ХҮСЛИЙН ЦОМОРЛИГ**

у. Хүсэл хэтэрснээс гаслан төрнө  
 Хүсэл хэтэрснээс аюул төрнө  
 Хүслийг тэвчиж чадваас л  
 Хөнөөх аюул гаслан үл тохионо  
 у. Жаргал ихэдвээс гасланд орно  
 Жаргал ихэдвээс зовлонг авч ирнэ  
 Жаргалд живэхийг тэвчвээс л  
 Заяа тэтгэж зовлонд үл орно  
 у: Хүсэл баяслын үр дагаварт  
 Хясал, зовлон ирдэг нь жам  
 Зүйрлэвэл амтлах үед сайхан ч

Зовиур эдлүүлэх халуун хор нь эцэст ирэх  
у. Хүслийн хүлээсэнд автагдсан аваас  
Хүчилж түүнээс гарна гэдэг бэрх  
Жаргал зовлон алиныг ч эдлэх байлаа  
Зугтан гарч чадваас тэр гайхамшиг  
у. Аль нэг элдэв хөнгөмсгийг хүсэн  
Ард олонд атхаг санан тачаадах  
Асар муу явдлыг тэвчиж чадаачин  
Алдрын дээдийг хүртээчин тэр буюу  
у. Хүн хэмээгчид мөнхийн хүсэгдэхүүн гэж үгүй  
Хүсэн тачаагаад байгаа юм ч мөнх бус  
Хүсэхгүй сэтгэлээ сайтар тэвчих ахул  
Үхлийн орноо одохын цагт хэрэг тэр  
у. Уран хүн эд мөнгөний хэрээр  
Оюун төгс эрдмийн чинээгээр  
Өчүүхэн эгшин бүрийн төдийд  
Өөрийн хүссэнээр хэргээ гүйцэтгэнэ  
у. Шунал хүсэлдээ хөтлөгдөн дагаачин  
Ханахыг үл мэдэн зүтгэсээр  
Алимад муу бодолд автагдан  
Адаг сүүлдээ биеэ эвдэнэ  
у. Онъчгүй хүслээ ямагт умартан  
Оюун билгээр ханан жарга!  
Оюун билгээр ханасан хүн  
Орчлонд хурьцахын зовлонд үл орно  
у. Эд уурсанд автагдсан мунхаг оюутан  
Ирээдүй цаашийг үл бодон зүтгэж  
Шунал сэтгэлийн хүлээс нь чангарсаар  
Өрөөл бусдыг өөртэйгөө хамт бүрэлгэнэ  
**Гурав. ХУРЬЦЛЫН АЙМАГ**  
у. Бие юугаа атхаг сэтгэлээр тэжээвэл  
Булай тачаангуй арвижих болно  
Тачаангуй арвижих сэтгэлийг эзэлбэл  
Тасаршгүй хүлээсэнд орох нь тэр бүлгээ  
у. Хүслийн харанхуй нүхэнд орон  
Хурьцлын манангаар өвч бүрхүүлэн  
Сэрэмжгүйн хүлээсээр бөх хүлэгдэгчид  
Өөшинд орсон загас лугаа адил буюу  
у. Сэрэмжгүй дураар явагч ардын  
Ороонги мод мэт хурьцал арвидаж  
Өтлөх ба үхэхийн цаг болоход  
Өлөн тугал эхийн хөхийг хүсэх мэт  
у. Хурьцахуй лугаа нөхцөхийг хичээгч  
Хуудуу муу үйлэнд төөрнө  
Үндсээр түүнийг тэвчигч тэр  
Уй гаслан аюулгүй болно  
**Дөрөв. СЭРЭМЖТЭЙН ЦОМОРЛИГ**  
у. Сэрэмжтэйд үхэл алс оршино  
Сэрэмжгүйд үхэл аяндаа ирнэ  
Сэрэмжтэй нь үхэлд үл өртөнө  
Сэрэмжгүй нь үхэлд үргэлж өртөнө  
у. Сайн мэргэд сэрэмжлэхийг ухаж  
Сааралгүй үнэний замыг олоход  
Сэрэмж муутай мунхгууд харин

Сэтгэлийн тамыг эдэлж бүрүүн  
у. Хичээнгүй хийгээд сэрэмжтэй нь  
Бурангуй мууг номхотгон чадна  
Илтэд үзэхгүй сайн мэргэд  
Их мөрнийг санагдуулах дөлгөөн буюу  
у. Сэрэмжийг ёс төдий бодоочин  
Сэтгэлчлэн яаж үйлс нь бүтэх  
Худалдаачин эд уурсанд шунах мэт  
Хуурмаг мэргэдийг бишрэх буюу  
у. Хичээнгүй сэрэмжийг магадад баримталбал  
Явдал ариутан үйлс шинжлэлтэй болно  
Номын ёсыг үнэхээр дагаачин аваас  
Нотод хичээнгүйг олж алдар арвижна  
у. Олон янз учир зүйг өгүүлэхүйд  
Онцгой сэрэмжээр сайныг мэдээчин  
Бусдын юманд үл шунаж  
Буяны мөрийг хөөгөөчний адил  
у. Энэ насны учир гэж юу вэ?  
Эцэс хойтын учир гэж юу вэ?  
Үүнийг оноож хэн мэдсэнээр  
Үнэн мэргэнд тооцогдох буюу  
у. Сэрэмж алдаж мууг үзээчин  
Сэтгэлдээ нэгийг тээж үлдэнэ  
Хотол ертөнцийн ёсонд бишрэн  
Хутаг Өлзийг өөрөө ононо  
у. Нойр хийгээд зальхайг эс сэрэмжилбэл  
Бодсон эс бүтэж өөрт гай ирэх  
Үнэнээр яваа гэж биеэ зөвтгөсөөр  
Үзтэл буруу муугийн тоонд орно

**Тав. АМРАГИЙН ЦОМОРЛИГ**

у. Амрагуудаас гаслан төрнө  
Гаслангаас аюул төрнө  
Амрагийг тэвчиж чадвал  
Аюул гаслан үл төрнө  
у. Эмс амраг хэт ихэдвэл  
Элмэд муу гаслан тарина  
Эрхбиш учиртай тэвчиж явбал  
Гаслан тарих нь хомс болно  
Амраглан нөхөрлөхийг үл үзвэл зовлон  
Амраглахыг хэт үзвэл мөн түүнчлэн зовлон  
Гагцхүү баяр зовлонг төгөлдөр мэдвээс  
Гамшгаас ангид байж болох буюу  
у. Амрагаас ангижран хагацах нэг зовлон  
Амраг бус лугаа учрах хоёр зовлон  
Ад зэтгэр болж холдох шившиг  
Асар муугаа дуудалцан тэрсэлцэх бас шившиг  
у. Амрагууд биесийг жаргалангаар бэхэлж чадвал  
Аль алинд зовлонг ямагт үл эдлүүлнэ  
Үйлдэх нүглийн замаас хол байж  
Үхэх ба өтлөхийн мөрийг дагаж одно  
у. Өөрийгөө баясгахыг хичээхээс зайлж  
Өрөөл амрагийг үнэн баясгаж чадваас  
Амрыг бодож гэмийг огоорсон нүгэлтэйд  
Асар их сургаал болох учир нэгэн буй

у. Амар хялбарыг олох гэж хичээгчид  
Алсдаа сайны мөрийг алдаж осолдон  
Нэгэн биеийн жаргал хөөх сэтгэл  
Насан туршид зовлонгийн үр тарина  
у. Засаглалаар хол газар цөлөгдсөн хүн  
Заяа тэтгэн эргэж ирэх аваас  
Амраг садан анд олон нь  
Аяа гайхамшиг хэмээн баясалдана  
у. Номыг үзэн хотол төгссөн мэргэд  
Ичгүүрийг мэдэж үнэнийг өгүүлэхүй  
Бусдыг баясган өөрийгөө дагуулж  
Буруугүй зөвийг ухаарахын увьдас өгнө

#### **Зургаа. САЙН ЯВДЛЫН ЦОМОРЛИГ**

у. Муу явдлыг биеэр тэвчээд  
Сайн явдлыг биеэр үйлдэх нь  
Хэргээс биеэ зайлуулж чадах  
Хичээнгүйгээр биеэ барьж чадах  
у. Хэлээр мууг өгүүлэхийг тэвчиж  
Хичээж сайныг өгүүлж сурваас  
Сэтгэл сэвгүй ариун болно  
Сэжиг зүхлээс зайлж чадна  
у. Сэтгэлдээ муу бодол үл агуул!  
Сэжиггүй сайхан бодлоос буян үүднэ  
Сэтгэлийн гэмийг сахиж чадваас  
Сэвгүй ариун үйлдэл аяндаа чуулна  
у. Буяныг биеэр үйлдэж арвижуул  
Буяныг хэлээр өгүүлж арвижуул  
Буяныг сэтгэлээр үүсгэж арвижуул  
Бие, хэл, сэтгэл гурвын буян энэ буюу  
Биеэр мууг үйлдэхийг тэвчигтүн  
Хэлээр мууг өгүүлэхийг цээрлэгтүн  
Сэтгэлээр мууг үүсгэхийг сахигтун  
Бие, хэл, сэтгэл гурвын нүгэл энэ буюу

#### **Долоо. ҮГСИЙН ЦОМОРЛИГ**

у. Үйлдсэн хэргээ үгүй гэж нуугаачин  
Өөрийгөө тамд оруулаачин буюу  
Үзтэл үйлийн мууг хийснээр  
Үнэнийг олохгүй үхдэл болох буюу  
у. Өнгөндөө сайн үг өгүүлэн муугаа нуугч  
Өөдгүй муу бэртэгчинг зүйрлэвэл  
Ялдам зангаар цээж юугаа дуугаргагч  
Ясан хумст мууртай юуны ялгаа  
у. Хэн илтэд баясалцах аваас  
Хилэнц үл төрүүлэх бүлгээ  
Итгэл дүүрэн тийнхүү баясалцал  
Эрхгүй зохисоор сайныг өгүүлэлдэнэ  
у. Үнэн үгс гэгч рашаан буюу  
Үнэнийг өгүүлэх гэгч буян буюу  
Үг утгыг сайтар номлох гэгч  
Үзвээс сайн үйлийн цагаан мөр буюу

#### **Найм. ҮЙЛСИЙН ЦОМОРЛИГ**

Илчит галыг өрдөн бадраахуйд  
Өөдөст төмрийг уяраахад хялбар  
Эрдэмтэн мэргэд залхайрч сэтгэлээ эс барьснаар

Иргэн улс түүнийг гэсгээхүй бэрх  
у. Гайт үйлээс хэн ч үл зайлна  
Газрын гүнд орлоо ч үл зайлна  
Гүн далайд шумбалаа ч үл зайлна  
Гүнзгий агуйд орлоо ч үл зайлна  
у. Хүн гэгч буянт ба нүгэлтэн  
Үйлдсэн нь ямар л байваас  
Үнэндээ хомс бага гэж үгүй  
Үр дагавар нь түүнчлэн адил буюу  
у. Амарлингуй баясгалант тавиун сэтгэл  
Агуулагч хүнийг тэтгэх үр буюу  
Үйл явдал мөнх бус ч гэлээ  
Үнэн мөний боловсрол их буюу  
у. Цаглашгүй муу үйл хэзээ ч  
Цагаан сүү мэт хувилах нь үгүй  
Утаат гал мэт манаран байж  
Үнс болтол шатааж мэдэх аюултай

#### **Ес. СҮСГИЙН ЦОМОРЛИГ**

у. Номонд сүсэглэх дээдсийн ёсон  
Нотод сүсгээр өглөг өгөх ачтан  
Тэнгэр нарны ертөнцөд одох  
Тэнцэшгүй их заяатан болно  
у. Харам сэтгэлтэн өглөгөөс зайлна  
Хамаг ихэс тусын тул номлоно  
Ухаантан ард өглөгтөө биширч  
Усгал сэтгэлээр амгаланг тогтооно  
у. Эрхэм дээд ёсон сүсэг бүлгээ  
Эрдэм номоор явагч жаргалан бүлгээ  
Үнэн ямагт бишрэлийн дээд бүлгээ  
Ухаан ямагт амьдралын дээд бүлгээ  
у. Ариун ном сүсгийг төрүүлж  
Атхаггүй сэтгэл баяслыг авчирч  
Мэргэдийн үгийг бишрэн сонсвоос  
Билгийн мөрөн түүнээс арвижна  
у. Сэрэмжтэнээр их далай хийгээд  
Сүсгээр мөрнүүдийг даруй гэтэлж  
Хичээнгүйгээр зовлонг тэвчиж  
Билгээр бэрхийг тайлан ариун болно  
у. Сүсэг хийгээд шагшабад хотол төгссөн  
Хармыг тэвчиж өглөгнүүдийг төгссөн хэнээр ч  
Хаа одвоос тэр газар бүхэндээ  
Хамаг хүндэтгэлийг хүлээн тахигдах болно

#### **Арав. БУЯНЫГ СУДЛАГЧИЙН ЦОМОРЛИГ**

у. Нум сумыг муу барьснаар  
Нуруу гараа гэмтээх лугаа адил  
Номын ёс, буяныг муу сахиснаар  
Нүгэлт тамд одоочингууд нэг бус  
Нөхмөл шар хувцсыг өмсөөчид  
Нүгэлт сэтгэлээ эс тэвчиж  
Ёс бус явдал номондоо баясан  
Ёозгүй муу заяанд унанам  
у. Эдүгээ тэргүүнээ цайх болтол  
Өтгөсийн үед эс орсон

Идэрийн цаг төгссөнийг мэдэхгүй  
Элдэвлэн явагч тэнэгийг яана  
**Арван нэг. МӨРИЙН ЦОМОРЛИГ**  
у. Салхин хөдөлж тоос босохуйд  
Сансраас хур бууж ариутгах мэт  
Аль нэгэн цагт билиг оюун дэлгэрэхүй  
Атхаг худал тэр үед арилах бүлгээ  
Үнэний дотроос дөрвөн үнэн чухаг  
Үсэгт номоос найман мөчит мөр дээд  
Хоёр хөлтний дотроос хосгүй сэтгэлт дээд  
Холбож хэлэх үгнээс хоёргүй шударга дээд  
у. Хуран үүдсэн бүгд мөнх бус  
Хожим нь худал болоод зовлон гэгдэнэ  
Хурц оюунаар шүүн бодох сэтгэлд  
Хоргодож үлдэх мөр магад арилна  
**Арван хоёр. ХҮНДЛЭЛИЙН ЦОМОРЛИГ**  
у. Хэзээ нэг цагт тэнэгүүд тахигдвал  
Хэтийн заяа сүйрэхийн үндэс  
Хожим хойтын залгамж үеийнхэнд  
Хувьгүй муухай эндэгдэл учирна  
у. Цээргүй мунхгууд олзыг хүснэ  
Цэцэн мэргэд нөхрийг хүснэ  
Харам сэтгэлтнүүд мууг үзэж  
Хавь ойрдоо үнээ алдана  
у. Худалд үл хичээн  
Хүнд сүсэглэхийг түрүү болгогсод  
Нутад бусад амьдралыг үл шүтвээс  
Номын ёсыг бишрэгч болох нь буй  
у. Өөрийн олзоор үл хөөрөлхөн  
Бусдын олзонд бүү шуна!  
Тийнхүү тачаадан шунагч  
Тэнсэлгүй муу заяанд унах буюу  
у. Жаргалтай амьдрахын хүслэнд автвал  
Заяа буяны үйлийг ямагт тэтгэ!  
Хулганы нүх эзэлсэн могой мэт  
Хувиа бодон биеэ бүү нөөцөл!  
**Арван гурав. УРЛАХЫН ЦОМОРЛИГ**  
у. Нүгэлт үйлийг үл үйлдэв гэлээ ч  
Нүдээр харахуйд урлахуй бусыг урлавал  
Энэ ба хойт хэзээ ч байлаа  
Эргээд ирдэг бүрэлгэн үйлдэгч  
у. Сайн мэргэдийн номлосон үг  
Саруул ухааныг тэтгэдгийн адил  
Сааршгүй буянтны үйлийн үр  
Сааталгүй дээдийн жаргал хайрлана  
у. Намайг муушаан, намайг хорлоно гэж  
Надаас булааж би ялагдана гэж  
Өөрөө өөрийгөө сэжиглэн сэтгэгч  
Өнөд нүгэл хураан үл амарлина  
у. Бусдад өшиж биеэ зовоогч  
Буянаа барж амгалан үл болох  
Тэвчин хүлцэж өш үл сэтгэвээс  
Тэнгэр ивээсэн жаргаланг эдэлнэ

у. Өшилснөөр өштөнөө үл номхруулна  
 Өгөөмөр тус өштөнийг номхруулна  
 Мунхаг л өшөөр өөрийгөө хорлоно  
 Мэргэд харин өшөө үл үйлдэнэ  
 у. Чин шударга үнэн сайн нөхдөө  
 Цэвдэг муу үгээр бүү басамжил  
 Алжаасан цагт бат түшиг болох  
 Ариун журмыг үүрд сахигтун!

**Арван дөрөв.**

у. Ач төгс бурхны дуртгал ёсоор  
 Амьсгал авах цаг хэзээ татрах нь  
 Ашид их баясалгалыг сайтар шүтсэнээр  
 Үүлэн чөлөөний наран саран мэт  
 Үнэхээр тодорхой агаад богиныг мэдэлтэй  
 у. Сэргэг байж нойронд үл нозоорох нь  
 Сахиул болж болгоомжлохын учир тэр  
 Сэтгэл үл тэвчин нойронд умбах нь .  
 Сэрэмж алдсан молхи нэгэн буюу  
 у. Өдөр хийгээд шөнө алинд ч болов  
 Олз хийгээд хөнөөлд сэтгэл тавиачин  
 Ослоос үл зайлж буяны мөрөө баран  
 Онхид муу тамын оронд хөтлөгдөнө

**Арван тав. ХЭСЭГ БУСГИЙН ЦОМОРЛИГ**

дх. Сэтгэлээ өгч, өөрөө үйлдэж сур!  
 Шамдаж хурднаар мэргэжин зохио  
 Хирийг арилгаж гэмгүй явбал  
 Хойшдын хэрэгт тус нь их  
 дх. Хэргэм зэрэг бага багаар ахина  
 Хэтэрхий мэргэд эгшин эгшнээр нэмнэ  
 Мөнгийг дархан урладаг адил  
 Мөнхүү сайнаа дархлан үлдээх  
 Ичгүүргүй бус юмнаас ичээд  
 Ичгүүрт юмнаас үл ичих  
 Үл айх юмнаас айх бөгөөд  
 Айвал зохихоос үл айх гэгч  
 Мунхаг агаад буруу үзэл  
 Муу заяанд унахын ёр бүлгээ

дх. Нүгэлт үйлийг сайтар тэвчээд  
 Номч мэргэд буяныг бясалгахуй  
 Хиргүй сэтгэлт аглагч (даяанч)  
 Хэзээд бэрхийг эрэн түүндээ баясана  
 дх. Хорт муу ургамал тариа гэмтээнэ  
 Хорон мунхаг хүн үйлэнд осолтой  
 Ургамлын мууг үндэс таслан салгах  
 Ухаан мунхгаас үтэр хагацан салах

**Арван зургаа. ХИРИЙН ЦОМОРЛИГ**

Залуу нас барагдах болно  
 Засаглах эрдэгийн дэргэд хүрнэ  
 Завсарт очих газар үгүй  
 Замын хүнээс чамд үгүй  
 Авиргүй муугаас согтон мунхрах  
 Архины хойноос даган хөөцөлдөх  
 Амраг хэмээн тачаадан явагч

Амар жаргалын үндсийг тасална.  
 Амьтны мөр огторгуйд үгүй  
 Ариун санаанд хор үгүй  
 Алдар цууд мөнх үгүй  
 Ачтан хүнд хор үгүй  
 Зан үйл үгүй бол тарничийн гэм  
 Завсрын хов их бол үйлсийн гэм  
 Залхуу хойрго бол язгуурын гэм  
 Зальхай сэрэмжгүй бол сахилгын гэм  
 Хэмжээгүй самуурах хатагтайн гэм  
 Хармын сэтгэл өглөгчийн гэм  
 Ханашгүй жаргах сэтгэлийн гэм  
 Хамгийн гэм нь хилэнцийн гэм  
 Бусдыг хөнөөн амийг таслах  
 Бусдыг мэхлэн худал хэлэх  
 Бусдын эдийг хулган авах  
 Бусдын эхнэрийг хууран дагуулах  
 Бузар булай тэр агаад  
 Булшлагдах тавилан тэр бүлгээ...

**Д. ДАШДОРЖ**  
**Д. ЭРХЭМБАЯР**

«МИЛЫН НАМТАР»-ЫН  
 ДӨТГӨӨР БҮЛЭГ

**ДЭЭДЭД БОЛСОН АМАРЛИНГУЙ  
 МУУ ГАСЛАНГААС ГЭТЭЛГЭСНИЙ  
 ЗОХИОЛ БУЮУ II ХЭСЭГ**

1. Уйдаx хийгээд магад гансарахын үүднээс билгэ төгөлдөр багштай уулзсаны зохиол.
2. Гэгээнээс юу зарлигласныг авах бөгөөс зовлонд сэтгэл гутарсныг зарлигт шүтээд хилэнц, түйтгэрийг хоцроолгүй судалсаны зохиол.
3. Энэрэл нигүүслэхүйд даган барьснаас боловсруулан гэтэлгэх увидсыг олсны зохиол.
4. Тэр ямагт (миларайба) багшийн дэргэд бясалган анхаарал онолын ногоо (эрдэм) мэндэлсний зохиол.
5. Увидасанд өөрөө аяндаа багтан орохын цагт зүүдэн мөрийн дохиог сануулснаар үгэн дамжлага увидас олох бөгөөс багшийн дэргэдээс заларсаны зохиол.
6. Ер бас шалтгаанаар орчлонгийн шим үгүйд гэрэл тодорхой тул бүтээлийг сэтгэлдээ тангарагласны зохиол.
7. Багшийн зарлигийг бүтээхийн тулд энэ нас оюунаа зориулах бөгөөс чин зориг хийгээд бэрх хатууг чандлан алмайралгүй аглагт (ууланд) бясалгасны зохиол.
8. Тэр мэт бясалгасан тул анхаарал онол арвидан дэлгэрэхэд одсоноос туйлд нь хүргэх бөгөөс бүтээлийн үрээр шашин-амьтны тус хайрласны зохиол.